



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.03.04 № 03/291

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан НХААГ/20240103199 дугаартай "Yutong bus ZK6116HG автобусанд хөрөнгийн даатгал"-ын үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга хүссэнтэй холбогдуулан дараах тодруулгын хариуг хүргүүлж байна.

| № | Оролцогчийн тодруулга | Захиалагчийн тодруулгын хариу |
|---|--|--|
| 1 | Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.2-т заасан 2021, 2022, 2023 оны санхүүгийн тайланд Санхүүгийн зохицуулах хорооноос хорооны дүгнэлт ирүүлэхээр заасан боловч 2023 оны санхүүгийн тайланд хийсэн дүгнэлт хараахан эцэслэж дуусаагүй байна. Тус дүгнэлт нь тендерийн эцсийн хугацаанаас өмнө албажиж гарч амжихгүй нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. | Тус асуудлаар захиалагч байгууллага нь 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 03/242 дугаар албан бичгээр Санхүүгийн зохицуулах хорооноос тодруулга авахаар хүргүүлсэн. Тус хорооноос 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 3/745 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн болно. (Албан бичгийг хавсралтаар оруулав.) Уг асуудлаар тендер шалгаруулалтын баримт бичиг өөрчлөлт оруулаагүй болно. |
| 2 | Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.2-т заасан Төлбөрийн чадварын зохистой харьцаа 100%-иас дээш байх (2023 оны жилийн эцсийн байдлаар) байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 559 дүгээр тогтоолоор "Даатгалын багц дүрэм"-ийн хоёрдугаар хавсралтыг шинэчлэн баталсан тул тус заалтыг хянаж, шинэчилж өгнө үү. | Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 559 дүгээр тогтоолоор "Даатгалын багц дүрэм"-ийн хоёрдугаар хавсралтыг шинэчлэн баталсан тул: Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгт дэх ТШЗ 18.2 дахь хэсгийн "Төлбөрийн чадварын зохистой харьцаа 100%-иас дээш байх (2023 оны жилийн эцсийн байдлаар)" гэснийг; "Төлбөрийн чадварын зохистой харьцаа шинэчилсэн журмын 2.19.2.Хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай" буюу түүнээс дээш гэж өөрчилж байна. |

| | | |
|---|---|--|
| 3 | <p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.2 дахь хэсгийн “б”-д шаардсан Тендерт оролцогчийн үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгах боломжгүй тохиолдолд сүүлийн 3 сар буюу 2023 оны 11, 12 дугаар сар, 2024 оны 01 дүгээр сарын НД-7, НД-8 нийгмийн даатгалын төлөлтийг цаасан хэлбэрээр ирүүлнэ гэснийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан “Ажил олгогчийн 2024 оны 01 болон 02 дугаар сарын нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн тайланг 03 дугаар сарын 15-ны өдрийн хүртэл шинэ системээр хүлээн авч байна” гэсэн мэдэгдэл 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр байршуулсан байгаа тул дээрх асуудалд тодруулга гаргаж өгнө үү.</p> | <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын системийн шинэчлэлт хийгдэж байх тул тайлан хүлээн авах хугацааг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сунгасантай холбогдуулан тендер хүлээн авах эцсийн хугацаа болон тендер нээх өдөрт холбогдох хууль, журмын дагуу өөрчлөлт оруулж сунгасан болно.</p> <p>Тус тодруулгатай холбоотойгоор тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2 дахь өөрчлөлт оруулаагүй болно.</p> |
|---|---|--|

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийг үндэслэн тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 09 цаг 00 минут, тендерийн нээлт хийх хугацааг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 09 цаг 30 минут болгон өөрчлөлт оруулсныг үүгээр мэдэгдэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 2 хуудастай.